

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : **2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **“Ажлын хувцас” нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ/202212555**

“Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газар нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан хуулийн этгээдийг **“Ажлын хувцас”** нийлүүлэх тухай тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер шалгаруулалт нь нэр бүхий **2 /хоёр/** багцаас бүрдэнэ.

Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендерийн баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд тендерийн баримт бичгийн үнэ **50,000.0 /тавин мянга/** төгрөг төлснөөр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй болно.

Тендер нь түүнийг нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд тендерийн хамт дор дурдсан үнийн дүн бүхий тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

Багц 1: 2,110,000 /хоёр сая нэг зуун арван мянга/ төгрөг

Багц 2: 1,413,000 /нэг сая дөрвөн зуун арван гурван мянга/ төгрөг

Тендерийн баталгаа нь тендер нээсэн өдрөөс хойш 58 /тавин найм/ хоног дуустал хугацаанд хүчинтэй байна.

Тендерийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө тендерийн баримт бичигт заасан журмын дагуу www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлэх ба тендерийн нээлтийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 05 минутад цахим системээр зохион байгуулна.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхгүй”**

Урьдчилсан худалдан авах ажиллагааны урилга эсэх: **“Үгүй”**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг www.tender.gov.mn цахим хаягаар болон доорх хаягаар хүргүүлж болно. Хаяг: Улаанбаатар хот, БЗД, Энхтайваны өргөн чөлөө 98, 102 тоот өрөө, утас:450060-142.

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ